

“Улаанбаатар БҮК” ХК-ийн ТУЗ-ийн 2022

оны 7 сарын 25-ны өдрийн №

1021/18... тоот Тогтоолын хавсралт

№...3

“УЛААНБААТАР БҮК” ХК-ийн ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү баримт бичгээр “Улаанбаатар БҮК” Хувьцаат Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны бодлогыг тодорхойлно.
- 1.2. “Улаанбаатар БКК” ХК-ийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааг хангах бодлогын зорилго нь (цаашид Бодлого гэх) урт хугацаанд компани, түүний хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн бодитой, хараат бус дүгнэлт, оновчтой шийдвэр гаргах чадвартай ТУЗ болон бусад эрх бүхий албан тушаалтнуудын мэргэшсэн, үр дүнтэй багийг бүрдүүлэх үндсэн зарчим, журмыг тодорхойлоход оршино.

Нэр томъёоны тодорхойлолт:

Төлөөлөн Удирдах Зөвлөл буюу “ТУЗ” гэдэгт Компанийн Төлөөлөл Удирдах зөвлөл, үүнд тухай бүр шинээр болон улиран сонгодсон бүрэлдэхүүнийг ,

Компани гэдэгт “УЛААНБААТАР БҮК” Хувьцаат Компанийг,

Эрх бүхий албан тушаалтан гэдэгт “Улаанбаатар БҮК” ХК-ийн “Дүрэм”-ийн 7.54-д заасан ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, компанийн албан ёсны шийдвэр гаргахад болон гэрээ хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээд буюу хэлтэс албадын удирдлагууд ,

Нэр дэвшүүлэх хороо буюу **Хороо** гэдэгт Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу томилогдсон буюу улиран томилогдсон ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог

Тус тус ойлгоно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулж ТУЗ-д танилцуулж батлуулах арга хэмжээ авна.
- 2.2. Хороо нь эрх бүхий албан тушаалтны томилгооны асуудлыг Компанийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл, зорилго, зорилттой уялдуулах арга хэмжээ авч ажиллана.
- 2.3. Хороо нь эрх бүхий албан тушаалд дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба түүнийг хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх замаар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.4. Өндөр насны тэтгэвэрт гарах болон таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо болон гүйцэтгэх удирдлага нь жил бүрийн давтамжтайгаар судалгаа хийнэ.
- 2.5. Гүйцэтгэх захирал нь Хүний нөөцийн чиг үүрэг эрхэлсэн захирал, /алба, хэлтсийн дарга/-ын

тусламжтайгаар албан тушаал дэвшүүлэн ажиллуулах ажилтнууд болон тогтоон барих, түлхүүр ажилтнуудыг тодорхойлж, ур чадварыг нь хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, хяналт тавих, үнэлж дүгнэх зэрэг үйл ажиллагааг хариуцах ба Хорооноос шаардлагатай дэмжлэг туслалцаагаар хангана.

ГУРАВ. ХЯНАЛТ САЙЖРУУЛАЛТ

3.1. Энэхүү бодлого болон холбогдох журмуудын хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүн, түүнийг дагалдах залгамж халааны төлөвлөгөө үр дүнтэй хэрэгжиж буй эсэхэд хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгнө.

3.2. СЗХ, МХБ эсхүл холбогдох бусад эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагын дагуу Бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг ТУЗ эдэлнэ.

ДӨРӨВ. БОДЛОГЫН ТАЛААР НИЙТЭД МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ТУХАЙ

4.1 Бодлогын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Компанийн жилийн эцсийн тайланд оруулж Бодлогын баримт бичгийг Компанийн цахим хуудсанд байршуулна.

ТАВ. БУСАД

5.1. Энэхүү журам нь ТУЗ-ийн тогтоолоор баталсан өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

-ооо-